# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

## Агуулга

1. Аудитын гэрчилгээ ....................2
2. Аудитын тайлан ....................4
2.1. Оршил ....................4
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага ....................4
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт ....................4
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин ....................5
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ ....................5
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал ....................5
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар ....................5
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд ....................6
2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга ....................7
2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн ....................7
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал ....................8
2.12. Шилэн дансны мэдээлэл ....................8
2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт ....................8
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл ....................8
3. Менежментийн захидал ....................9
4. Аудит хийсэн санхүүгийн тайлан ....................10
4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан ....................10
4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан ....................12
4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан ....................14
4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан ....................16
4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан ....................17
5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт ....................19

### Товчилсон үгийн жагсаалт

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| АОУС | Аудитын Олон Улсын Стандарт |
| УТХО | Улсын төсвийн хөрөнгө оруулалт |
| ТБОНӨХБАҮХ | Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль |

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

2020.03.13 № 06/793
танай ______________-ны № _______________-т

ҮНДЭСНИЙ ДАТА ТӨВ УТҮГ-ЫН
ЗАХИРАЛ М.БАТТУЛГА ТАНАА

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Үндэсний Дата төв УТҮГ-ын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

**Зөрчилгүй санал дүгнэлт**

Үндэсний Дата төв УТҮГ-ын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн стандарт болон холбогдох хууль тогтоомжийн дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

**Санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Үндэсний Дата төв УТҮГ-ын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, тодруулга дах үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

\\10.10.10.20\Bichig_Khereg\Yawsan_Bichig\2020\0313SAG25.Docx

001051222

**Үүрэг, хариуцлага**

Үндэсний Дата төв УТҮГ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг УСНББОУС, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох хууль тогтоомжийн дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ

9006109
9019120396

\\10.10.10.20\Bichig_Khereg\Yawsan_Bichig\2020\0313SAG25.Docx

## 2. Аудитын тайлан

### 2.1. Оршил

Үндэсний дата төв УТҮГ-ын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг захирал М.Баттулга Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн худалдан авалтын үйл ажиллагааг хууль журмын дагуу зохион байгуулах  зөвлөмжийг Менежментийн захидалд тусгасан болно.

### 2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Үндэсний дата төв” УТҮГ-ын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, тодруулга, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Үндэсний дата төв УТҮГ-ын 2019 оны санхүүгийн тайлан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох хууль тогтоомжийн дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд санал дүгнэлт гаргах нь энэхүү аудитын зорилт байв.

Үндэсний дата төв УТҮГ-ын удирдлага нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг УСНББОУС Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох хууль тогтоомжийн дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 11 дүгээр сарын 11-нээс 2020 оны 3 дугаар сарын 09-ний хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 3 дугаар сарын 13-ны өдөр эцэслэн баталгаажуулж, байгууллагын удирдлагад хүргүүлэхээр төлөвлөн, “Эс Жи Эм Ди Аудит” ХХК-ийн аудитын баг хариуцаж хэрэгжүүлэв.

“Үндэсний дата төв” УТҮГ-ын 2019 оны санхүүгийн тайланг “Эс Жи Эм Ди Аудит” ХХК-д 2020 оны 1 дүгээр сарын 17-ны өдрийн 01/56 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

### 2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

### 2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Үндэсний дата төв УТҮГ нь үйл ажиллагааны зорилгоо “Монгол Улсын цахим үйлчилгээний дэд бүтэц, суурь хөгжлийг бид бэхжүүлэх.” гэж тодорхойлсон байна.

Үндэсний дата төв нь Монгол Улсын Засгийн Газрын 2009 оны 183 дугаар тогтоолоор байгуулагдсан бөгөөд Монгол Улсын үндэсний цахим мэдээллийн хадгалалт, хамгаалалт, боловсруулалтын үйлчилгээ эрхлэх үндсэн үүрэгтэй байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль ;
- Нийгмийн даатгалын шимтгэлийн тухай хууль;
- Хувь хүний орлогын албаны татварын тухай хууль;

### 2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус Үндэсний дата төв УТҮГ мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Үндэсний дата төв УТҮГ нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд “Unicus” программ хангамж ашигладаг байна.

Үндэсний дата төв УТҮГ ны дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

### 2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Үндэсний дата төв УТҮГ-ын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 8 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

### 2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2018 оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардлаар сонгож, эрсдэлийн түвшинг дунд гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 .0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 5,266.2 сая төгрөгөөс тооцон 105.3 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, Б201 маягтаар баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2019 оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардлаар сонгож 94.9 сая төгрөгөөр тооцсон болно.

## 2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Үндэсний дата төв УТҮГ-ын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 3,528.7 сая төгрөгөөр буюу 189.0 хувиар нэмэгдсэн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/сая төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө | 11.2 | 211.3 | 200.1 |
| Авлага | 23.9 | 25.6 | 1.7 |
| Бараа материал | 249.8 | 277.7 | 27.9 |
| Урьдчилгаа | 3.0 | - | (3.0) |
| Үндсэн хөрөнгө | 3,529.7 | 6,623.0 | 3,093.3 |
| Биет бус хөрөнгө | 141.8 | 350.6 | 208.8 |
| **Нийт хөрөнгийн дүн** | **3,959.4** | **7,488.2** | **3,528.8** |
| Өглөг | 12.2 | 220.9 | 208.7 |
| **Өр төлбөрийн дүн** | **12.2** | **220.9** | **208.7** |
| Өмч: Засгийн газрын оролцоо | 6,840.2 | 6,840.2 | 0.0 |
| Хуримтлагдсан үр дүн | (3,089.0) | 231.0 | (2,858.0) |
| Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 196.1 | 196.1 | - |
| **Нийт өр төлбөр ба эздийн өмчийн дүн** | **3,959.4** | **7,488.2** | **3,528.8** |

Өмнөх оны үзүүлэлтээс мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал,үндсэн хөрөнгийн данснуудад материаллаг өөрчлөлт гарсан байна. Тухайлбал:

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 200.2 сая төгрөгөөр өссөн нь УТХО-аар хэрэгжсэн төсөл арга хэмжээний нийт үнийн дүнгийн барьцаа хөрөнгөөс шалтгаалжээ.

Авлага дансны үлдэгдэл өссөн нь татаас санхүүжилтийн болон төлбөртэй үйлчилгээний авлага нэмэгдсэнээс шалтгаалжээ. Авлага дансны үлдэгдэлд 2018 онд үүссэн, он дамжсан 0.7 сая төгрөгийн байгууллагаас авах авлага байна. Үүнээс барагдах боломжгүй, эрсдэлтэй авлага үгүй байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 27.8 сая төгрөгөөр өссөн нь бичиг хэргийн болон сэлбэг хэрэгслийн материалын үлдэгдэл нэмэгдсэнээс шалтгаалжээ. Тайлант онд 844.2 сая төгрөгийн худалдан авалт хийсэн, байгууллагын үйл ажиллагааны онцлогоос шалтгаалан мэдээллийн технологийн тоног төхөөрөмжүүдийн тасралтгүй найдвартай ажиллагааг хангах зорилгоор сэлбэг хэрэгслийн тодорхой нөөц үүсгэсэн байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 3,302.1 сая төгрөгөөр нэмэгдсэн нь тайланд онд Хөрөнгө оруулалтаар 3,914.6 сая, худалдан авсан 209.3 сая төгрөгийн хөрөнгийн дүнгээр тус тус өссөнөөс шалтгаалжээ. Хуримтлагдсан элэгдлийн дүн 822.0 сая төгрөгөөр нэмэгджээ.

Биет бус хөрөнгө өссөн нь тайлант онд 253.7 сая төгрөгийн биет бус хөрөнгө худалдан авснаас шалтгаалжээ.

Өр төлбөр дансны үлдэгдэл өссөн нь байгууллагад төлөх өглөг өссөнөөс шалтгаалжээ.

Өр төлбөр дансны үлдэгдэлд 2019 оны хөрөнгө оруулалтын 195.7 сая төгрөгийн барьцаа хөрөнгө нь нийт өр төлбөрийн 88.6 хувийг эзэлж байна. Бусад 25.1 сая төгрөгийн өглөг нь байгууллагын үйл ажиллагааны онцлогоос шалтгаанаас үүссэн байна.

## 2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Үндэсний дата төв” УТҮГ нь тайлант онд 1,957.4 сая төгрөгийн орлого бүрдүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 1,957.4 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 100.0 хувиар биелүүлсэн байна.

Нийт зардлын 6,305.8 сая төгрөгийг улсын төсвөөс, 1,957.4 сая төгрөгийг үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс урсгал зардалд 2,191.8 сая төгрөгийн санхүүжилт, хөрөнгийн зардалд 3,914.8 сая төгрөгийн санхүүжилт авч, үндсэн үйл ажиллагаанаас 2,538.0 сая, нийт 8,644.5 сая төгрөгийн орлого бүрдүүлж ажилласан байна.

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөрт зориулан 8,263.2 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 4,254.1 сая төгрөгийг урсгал зардалд, 4,000.0 сая төгрөгийг хөрөнгийн зардалд, 9.1 сая төгрөгийг нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардалд зарцуулахаар батлагджээ. Гүйцэтгэлээр урсгал зардалд 4,133.7 сая төгрөг, хөрөнгийн зардалд 3,719.0 сая төгрөгийг зарцуулсан, 119.0 сая төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн, 591.7 сая төгрөгийг төсвийн ерөнхийлөн захирагч хооронд олгосон байна.

Тайлант жил урсгал зардлын гүйцэтгэл 4,124.6 сая төгрөг буюу 96.9 хувь, бусад урсгал шилжүүлэг буюу нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардал 9.1 сая төгрөг буюу 100 хувийн гүйцэтгэлтэй байна.

Хөрөнгө оруулалтын 1 төсөл, арга хэмжээнд 4,000.0 сая төгрөгийн санхүүжилт батлагдсанаас гүйцэтгэлээр 3,719.0 сая төгрөгийг зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 4,725.6 сая төгрөг буюу 96.9 хувьтай байгаа нь байр ашиглалтай холбоотой тогтмол зардал, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж болон бараа үйлчилгээний бусад зардал хэмнэгдсэнтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

## 2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 8 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 4 эрсдэл тодорхойлж нийт 12 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 35.9 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 35.9 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлж,алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өглөө. Үүнээс:

1. Тендер зохион байгуулалгүй 35.9 сая төгрөгийн сэлбэг хэрэгсэл худалдан авсан нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4-д “Тендер шалгаруулалтын журмыг сонгохдоо тухайн бараа, ажил, үйлчилгээний нийт төсөвт өртгийг үндэслэл болгоно.”, 8 дугаар зүйлийн 5 “Энэ хуулийн 8.1 дэх хэсэгт заасан босго үнэд багтаах, эсхүл нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэхээс зайлсхийх зорилгоор нийт төсөвт өртгийг хувааж хэд хэдэн тендер шалгаруулалт явуулахыг хориглоно.” заалттай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн эрх ба үүрэг, иж бүрэн байдал батламж мэдэгдлийг хангахгүй байна.

<u>Шийдвэрлэсэн нь</u>: Алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлсэн.

Аудитаар илэрсэн алдаа, зөрчилд 1 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

### 2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Дараагийн аудитаар авч үзэх нь анхаарал татах асуудал байхгүй гэж үзлээ.

### 2.12. Шилэн дансны мэдээлэл

"Үндэсний дата төв" УТҮГ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 126 мэдээллийг хугацаанд нь байршуулсан, 8 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

### 2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Нийт 4 зөвлөмж өгснийг хэрэгжүүлж, зөвлөмжийн хэрэгжилт 100 хувьтай байна.

### 2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Үндэсний дата төв УТҮГ-ын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Үндэсний дата төв УТҮГ-ын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

## 3. Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

### 1. Худалдан авалттай холбоотой асуудал

*1.1. <u>Илрүүлэлт:</u>*

ҮДТ//2019/01004 болон ҮДТ//2019/01005 дугаартай тендерүүдийн гүйцэтгэлийн баталгааг гэрээ байгуулснаас 2 хоногийн дараа авсан байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 43 дугаар зүйлийн 1 “Захиалагч «хамгийн сайн» үнэлэгдсэн тендер ирүүлсэн оролцогчоос гэрээ байгуулахаас өмнө гүйцэтгэлийн баталгаа ирүүлэхийг шаардаж болно.”, 43 дугаар зүйлийн 2 “Захиалагч гүйцэтгэлийн баталгааны дүнг гэрээний үнийн дүнгийн 5 хувиар тогтоож тендерийн баримт бичигт тусгана.”, 43 дугаар зүйлийн 4 “Захиалагч дор дурдсан нөхцөлд гүйцэтгэлийн баталгаа ирүүлэхийг гүйцэтгэгчээс шаардана:”, 43 дугаар зүйлийн 4.2 “100 сая төгрөгөөс дээш төсөвт өртөгтэй бараа, үйлчилгээ худалдан авах гэрээ байгуулах;” заалттай нийцэхгүй, эрх ба үүрэг, иж бүрэн байдал батламж мэдэгдлийг хангахгүй байна.

*1.2. <u>Эрсдэл:</u>*

Тендерээр гүйцэтгэж буй хөрөнгө оруулалтын ажлууд үр дүнгүй болох, ТБОНӨХБАҮХАТ хуулийн заалтыг хэрэгжүүлээгүй байх.

*1.3. <u>Өгсөн зөвлөмж</u>:*

Худалдан авах үйл ажиллагааг хууль журмын дагуу зохион байгуулж ажиллах,

*1.4. <u>Байгууллагаас өгсөн хариу тайлбар:</u>*

Холбогдох хууль журмыг мөрдөж ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 4. Аудит хийсэн санхүүгийн тайлан

### 4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

| Дансн ы код | Балансын үзүүлэлт | 2018 оны 12-р сарын 31 | 2019 оны 12-р сарын 31 |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **287,939,988.51** | **514,640,050.23** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | 11,191,503.0 | 211,346,129.01 |
| **311** | **Кассад байгаа бэлэн мөнгө** | 201.00 | 0.00 |
| 3110 | Төгрөг | 201.00 | 0.00 |
| **312** | **Банканд байгаа бэлэн мөнгө** | 500.00 | 195,987,215.01 |
| **3121** | **Төгрөг** | 500.00 | 195,987,215.01 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 0.00 | 195,738,215.01 |
| 31213 | Арилжааны банк дахь харилцах | 500.00 | 249,000.00 |
| 31400.0 | Замд яваа мөнгөн хөрөнгө | 11,190,802.0 | 15,358,914.0 |
| **33** | **АВЛАГА** | 23,949,392.82 | 25,627,300.00 |
| 33200 | Төлбөртэй үйлчилгээний авлага | 3,668,500.00 | 4,492,000.00 |
| 33300 | Татаас, санхүүжилтийн авлага | 0.00 | 20,904,500.00 |
| **335** | **Бусад авлага** | 20,280,892.82 | 230,800.00 |
| 3351 | Байгууллагаас авах авлага | 20,280,892.82 | 230,800.00 |
| **34** | **Урьдчилгаа** | 2,990,000.0 | 0.00 |
| 34600 | Урьдчилж төлсөн зардал | 2,990,000.0 | 0.00 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 249,809,092.69 | 277,666,621.22 |
| **354** | **Хангамжийн материал** | 249,809,092.69 | 277,666,621.22 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 19,318,898.25 | 29,879,908.49 |
| 35420 | Аж ахуйн материал | 42,895,074.35 | 41,576,164.67 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | 173,527,120.09 | 201,313,428.06 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 14,068,000.00 | 4,897,120.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **3,671,477,581.74** | **6,973,543,728.76** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 3,671,477,581.74 | 6,973,543,728.76 |
| **392** | **Биет хөрөнгө** | 3,529,658,356.90 | 6,622,968,536.59 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 2,053,120,168.95 | 2,497,153,610.95 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | 0.00 | (56,713,007.61) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 98,400,000.00 | 98,400,000.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (3,433,333.34) | (19,833,333.38) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 13,593,641,108.79 | 17,020,065,031.99 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (12,240,823,310.47 ) | (12,932,393,803.94 0 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 126,914,431.71 | 126,914,431.71 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (98,237,708.74) | (110701393.13) |
| 39217 | Ном | 77,000.00 | 77,000.00 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 141,819,224.84 | 350,575,192.17 |
| 39301 | Програм хангамж | 1,748,818,811.01 | 2,002,470,040.24 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (1,732,530,086.17) | (1,777,425,348.07) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 125,530,500.00 | 125,530,500.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **3,959,417,570.25** | **7,488,183,788.99** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **12,163,000.00** | **220,861,572.13** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 12,163,000.00 | 220,861,572.13 |

| | | | |
|---|---|---|---|
| **413** | **Өглөг** | 12,163,000.00 | 220,861,572.13 |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | 0.00 | 209,999.34 |
| **4136** | **Бусад өглөг** | 12,163,000.00 | 220,651,572.79 |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | 12,090,500.00 | 220,651,572.79 |
| 41362 | | 72,500.0 | 0.0 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **3,947,254,570.25** | **7,267,322,206.86** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 3,947,254,570.25 | 7,267,322,206.86 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 6,840,163,565.33 | 6,840,163,565.33 |
| 51101 | Өмч: - төрийн | 6,840,163,565.33 | 6,840,163,565.33 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | (3,089,044,797.59) | 231,022,839.02 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | (3,089,044,797.59) | (3,089,044,797.59) |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 0.00 | 3,320,067,636.61 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 196,135,802.51 | 196,135,802.51 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **3,959,417,570.25** | **7,488,183,788.99** |

**4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан**

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

| Дансны код | Үзүүлэлт | 2018 оны 12-р сарын 31 | 2019 оны 12-р сарын 31 |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **4,099,485,455.54** | **8,065,105,516.47** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **1,896,155,100.00** | **1,937,648,620.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 1,896,155,100.00 | 1,937,648,620.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 1,896,155,100.00 | 1,937,648,620.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 1,896,155,100.00 | 1,937,648,620.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **2,203,330,355.54** | **6,127,456,896.47** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 2,203,330,355.54 | 6,127,456,896.47 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 2,203,330,355.54 | 2,212,692,594.27 |
| 131005 | Хөрөнгийн санхүүжилт | 0.00 | 3,914,764,302.20 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **5,261,234,599.03** | **4,745,037,879.86** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **5,261,234,599.03** | **4,745,037,879.86** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 5,261,234,599.03 | 4,740,830,379.86 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 1,235,285,872.91 | 1,221,630,542.00 |
| 210101 | Үндсэн цалин | 1,113,346,109.80 | 1,153,041,681.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 43,623,000.00 | 55,298,250.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 78,316,763.11 | 13,290,611.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 143,639,267.56 | 151,303,256.85 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 143,639,267.56 | 151,303,256.85 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 407,797,255.51 | 466,799,838.67 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 287,371,705.46 | 316,037,747.18 |
| 210302 | Түлш, халаалт | 54,282,500.00 | 37,014,464.61 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 5,923,050.05 | 9,314,175.13 |
| 210304 | Байрны түрээс | 60,220,000.00 | 104,433,451.75 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 400,098,011.22 | 441,461,596.57 |
| 210401 | Бичиг хэрэг | 274,948,034.54 | 316,802,050.02 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 64,186,401.00 | 64,244,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернетийн төлбөр | 52,620,443.03 | 46,357,113.96 |
| 210407 | Аж ахуйн материал худалдан авах зардал | 8,343,132.65 | 14,058,432.59 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 42,7351,163.10 | 388,898,734.36 |
| 210604 | Урсгал засвар | 42,7351,163.10 | 388,898,734.36 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 1,816,000.00 | 45,294,000.00 |
| 210701 | Гадаад албан томилолт | 0.00 | 16,650,154.00 |
| 210703 | Зочин төлөөлөгч хүлээн авах | 1,816,000.00 | 28,643,846.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 766,802,115.58 | 1,180,722,169.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 100,923,512.00 | 109,102,102.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 5,960,000.00 | 5,960,000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 40,000.00 | 213,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 653,378,962.58 | 1,055,228,162.00 |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 6,499,641.00 | 10,218,905.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 1,878,444,913.15 | 844,720,242.41 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 180,000.00 | 1,476,835.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 28,332,120.00 | 21,200,960.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 1,849,932,793.15 | 822,042,447.41 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 0.00 | 4,207,500.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 0.00 | 4,207,500.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 0.00 | 4,207,500.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **(1,161,749,143.49)** | **3,320,067,636.61** |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **(1,161,749,143.49)** | **3,320,067,636.61** |

**4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

| Дансны код | Үзүүлэлт | 2018 оны 12-р сарын 31 | 2019 оны 12-р сарын 31 |
|---|---|---|---|
| 1 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН** | **5,053,988,800.00** | **8,763,582,082.17** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **2,408,440,700.00** | **2,537,993,079.97** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 2,408,440,700.00 | 2,537,993,079.97 |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | 2,408,371,200.00 | 2,537,993,079.97 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 2,408,371,200.00 | 2,537,993,079.97 |
| 120009 | Бусад орлого | 69,500.0 | 0.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **2,645,548,100.00** | **6,225,589,002.20** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 2,645,548,100.00 | 6,225,589,002.20 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 2,645,548,100.00 | 2,310,824,700.00 |
| 131005 | Хөрөнгийн санхүүжилт | 0.00 | 3,914,764,302.20 |
